



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/38

Бор-Өндөр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 31.1.1 дэх хэсэг, 32.1.7 дахь хэсэг, 32.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИАРМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын Хүйх 5 дугаар багийн малчин Х.Дарханбаатарын хонинд цэцэг өвчний шинж тэмдэг илэрсэн бөгөөд тус өрхийн ойролцоо хаваржиж буй 3 малчин өрхүүдийн хашаа хороонд халдваргүйтгэл хийх, сэжигтэй малд үзлэг хийх ажлын зардалд 705 000 /долоон зуун таван мянга/ төгрөг, сумын хэмжээнд малын сэг зэм устгах ажлын шатахууны зардалд 5 000 000 /таван сая/ төгрөг, Улсын онцгой комиссоос сумдад хуваарилсан тусламжийн гурил, будаа татан авах ажлын шатахууны зардалд 1 682 000 /нэг сая зургаан зуун наян хоёр мянга/ төгрөгийг тус тус гамшгийн эрсдлийг бууруулах сангаас зарцуулсугай.

2. Гамшгийн эрсдлийг бууруулах сангаас зарцуулах 7 387 000 /долоон сая гурван зуун наян долоон мянга/ төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ